



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/76

Хөхбүрд

Зориулалтын бус савгүй аян
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 11 дүгээр зүйлийн 11.1.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6, Хүнс, хөдөө аж ахуйн салбарын гуравласан гэрээний 4.2 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зориулалтын бус хуванцар сав, гялгар уут, нэг удаагийн гялгар улавчны хэрэглээнээс татгалзсан сум, баг болох аяныг 2023 оны 09 дүгээр сарын 11-нээс 2023 оны 12 дугаар сарын 30-ны хооронд зохион байгуулсугай.

2.Аяныг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, суманд зохион байгуулагдах "Зориулалтын бус савгүй" аяны удирдамжийг хоёрдугаар, аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Зориулалтын биш хүнсний хуванцар сав, нийлэг хальсан уут, улавчны хэрэглэхийг хориглох арга хэмжээ авч, хүнсний стандартад нийцсэн хүнсний зориулалтын савны хэрэглээг нэмэгдүүлж ажиллахыг 4-н багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Зориулалтын бус савгүй аянд зарцуулагдах урамшуулалын 150 000 (Зуун тавин мянган) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д, Нягтлан бодогч (Л.Алимаа) нарт зөвшөөрсүгэй.

5.Дээрх ажлыг чанартай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Орлогч (Г.Ганцоож)-д даалгасугай.

ДАРГА  Г.ОРХОНТУУЛ



642301159

Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 12-ний
өдрийн 176 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**“ЗОРИУЛАЛТЫН БУС САВГУЙ” АЯН СУМАНД
ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ УДИРДАМЖ**

Зорилго: Баянхонгор аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх, хүнс, худалдаа үйлчилгээний салбарын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын 107 дугаар заалтын зориулалтын бус хуванцар савыг хүнсний хэрэглээнд ашиглахгүй байх талаар соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах, зориулалтын савны худалдаа борлуулалтын зохион байгуулахад гол зорилго оршино.

Зохион байгуулах хугацаа: 2023 оны 09 дүгээр сарын 12-наас 2023 оны 12 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд чанартай зохион байгуулах.

Хамрах хүрээ: Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын аж ахуйн нэгж, Мандалхайрхан 1 дүгээр баг, Уранхайрхан 2 дугаар баг, Асгамба 3 дугаар баг, Мэргэн 4 дүгээр багийн малчин мал бүхий иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгч нар ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төвийг хамруулан зохион байгуулах.

Зохион байгуулах үйл ажиллагаа: Хүнсний сав, баглаа боодлын худалдаа, хэрэглээний талаар чиглэсэн мэдээ мэдээлэл, гарын авлага сургалт, сурталчилгааг хийх, аяны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулж биелэлт тус бүрийг хангаж ажиллах.

Хүний эрүүл мэндэд хортой, сөрөг нөлөөтэй нь тогтоогдсон хүнсний зориулалтын бус сав баглаа боодол, хэрэгслийг хүнсний худалдаа, сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг зэрэг газруудад хэрэглэхийг хориглох, өрхийн хэрэглээнээс халах арга хэмжээ авах.

Хүрэх үр дүн: Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын хэрэглээнд хэвшүүлэх, стандартын шаардлагад нийцсэн бетон, модон хувин, хөхүүр зэргийг хэрэглээнд нэвтрүүлж, сонголтоо өөрчилж, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж, зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээ буурсан байна.

_____оОо_____

Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 12-ний
өдрийн 176 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН СУМ,
БАГ, СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, ЭМНЭЛЭГ
ДЭЭР ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: М.Жавзансүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Отгонжаргал (Эрүүл мэндийн төвийн дарга)

Ж.Болормаа (Ерөнхий боловсролын сургуулийн

захирал)

Ж.Амартүвшин (Цэцэрлэгийн эрхлэгч)

Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Т.Цэцэгсайхан (Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг
дарга)

С.Энх-Амгалан (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг
дарга)

М.Сэр-од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Дагдансүрэн (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Ө.Ариузаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

_____оОо_____